Сурагчийн овог нэр: _____ Эхэлсэн ... он ... сар ... өдөр ... цаг

СЭДЭВ: НИЙЦТЭЙ БА НИЙЦГҮЙ ҮЗЭГДЛҮҮД VIII-22.1-I

Нэгэн зэрэг илрэх боломжгүй, өөрөөр хэлбэл харьяалагдах эгэл үзэгдлүүдийн олонлогууд нь огтлолцдоггүй ($A \cap B = \varnothing$) байх A ба B үзэгдлүүдийг нийцгүй үзэгдлүүд гэнэ.	Нэгэн зэрэг илрэх боломжтой буюу харьяалагдах эгэл үзэгдлүүдийн олонлогууд нь огтлолцдог ($A \cap B \neq \varnothing$) байх A ба B үзэгдлүүдийг нийцтэй үзэгдлүүд гэнэ.

Үзэгдлүүд нийцтэй эсэхийг тогтоо (**1-2**).

1. 8 улаан, 6 цэнхэр, 5 ягаан бөмбөгнөөс 1 бөмбөг авав.

а. A = “Цэнхэр эсвэл ягаан байх”, B = “Улаан байх”

б. A = “Цэнхэр эсвэл ягаан байх”, B = “Улаан эсвэл ягаан байх”

в. A = “Цэнхэр эсвэл ягаан биш байх”, B = “Улаан эсвэл ягаан байх”

г. A = “Цэнхэр эсвэл улаан биш байх”, B = “Улаан эсвэл ягаан байх”

2. Санамсаргүй 1 сурагч сонгов.

а. A = “10-аас дээш настай байх”, B = “10-аас ихгүй настай байх”

б. A = “8-аас дээш настай байх”, B = “10-аас дээш настай байх”

в. A = “7-оос дээш настай хүү байх”, B = “8-аас ихгүй настай байх”

Үзэгдлүүд нийцтэй эсэхийг тогтоогоод хэрэв нийцтэй бол огтлолцол олонлогийг бич (**3-5**).

3. 6 талт шоо орхив.

а. A = “Тэгш тоогоор буух”, B = “Сондгой тоогоор буух”

$A \cap B = \{$_____$\}$

б. A = “Тэгш тоогоор буух”, B = “4-өөс их тоогоор буух”

$A \cap B = \{$_____$\}$

в. A = “Тэгш тоогоор буух”, B = “3-т хуваагддаг тоогоор буух”

$A \cap B = \{$_____$\}$

4.



Зурагт өгсөн хүрдийг эргүүлэв.

а. A = “3 тоон дээр зогсох”, B = “Цэнхэр хэсэгт зогсох”

$A \cap B = \{$_____$\}$

б. A = “Тэгш тоон дээр зогсох”, B = “Цагаан хэсэгт зогсох”

$A \cap B = \{$_____$\}$

в. A = “4-өөс ихгүй тоон дээр зогсох”, B = “Цэнхэр хэсэгт зогсох”

$A \cap B = \{$_____$\}$

5. 2 оронтой 1 тоо санамсаргүй сонгов.

а. A = “3-т хуваагддаг тоо байх”, B = “3-т хуваагддаггүй тоо байх”

$A \cap B = \{$_____$\}$

б. A = “3-т хуваагддаг тоо байх”, B = “Сондгой тоо байх”

$A \cap B = \{$_____$\}$

Дасгалын дугаар																			Нийт
Өөрийн үнэлгээ																			
Багшийн үнэлгээ																			

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

Сурагчийн овог нэр: _____ Эхэлсэн ... он ... сар ... өдөр ... цаг

СЭДЭВ: НИЙЦТЭЙ БА НИЙЦГҮЙ ҮЗЭГДЛҮҮД VIII-22.1-II

Нийцгүй үзэгдлүүдийн нэгдлийн магадлал нь үзэгдэл бүрийн магадлалуудын нийлбэртэй тэнцүү.

$$P(A\cup B)=\frac{|A\cup B|}{|\Omega|}=\frac{|A|+|B|}{|\Omega|}=\frac{|A|}{|\Omega|}+\frac{|B|}{|\Omega|}=P(A)+P(B)$$

1. A ба B үзэгдлүүд нийцгүй бол энэ хоёр үзэгдлийн ядаж нэг нь илрэх үзэгдлийн магадлалыг ол.

а. $P(A)=\frac{1}{6}$, $P(B)=\frac{1}{3}$, $P(A\cup B)=$

б. $P(A)=\frac{1}{8}$, $P(B)=\frac{1}{7}$, $P(A\cup B)=$

2. A ба B үзэгдлүүд нийцтэй эсэхийг тогтоо.

а. $P(A)=\frac{1}{2}$, $P(B)=\frac{1}{3}$, $P(A$ эсвэл $B)=\frac{5}{6}$

б. $P(A)=\frac{1}{6}$, $P(B)=\frac{1}{9}$, $P(A$ эсвэл $B)=\frac{2}{9}$

3. Сургуулийн цайны газарт хийсэн судалгаагаар сурагчид хачиртай талх авах магадлал $\frac{1}{6}$, пицца авах магадлал $\frac{2}{3}$, гамбургер авах магадлал $\frac{1}{6}$ байв.

P(Хачиртай талх эсвэл пицца авах)=

P(Хачиртай талх эсвэл гамбургер авах)=

P(Пицца эсвэл гамбургер авах)=

4. Болд сургууль руугаа явганаар, эсвэл дугуйгаар, эсвэл автобусаар явдаг бөгөөд явганаар эсвэл дугуйгаар явах магадлал нь $\frac{3}{4}$, харин дугуйгаар явах магадлал нь $\frac{1}{4}$ байв.

а. P(Явган явах)=

б. P(Автобусаар явах)=

в. P(Дугуйгаар эсвэл автобусаар явах)=

5. Зогсоол дээр автобус цагаасаа хоцорч ирэх магадлал $\frac{1}{4}$ байв. Харин хоцорч ирэх эсвэл яг цагтаа ирэх магадлал $\frac{2}{3}$ байв.

а. P(Яг цагтаа ирэх)=

б. P(Цагаасаа эрт эсвэл яг цагтаа ирэх)=

6. Уутанд улаан, цагаан, ногоон өнгийн бөмбөгнүүд байв. Санамсаргүй 1 бөмбөг авахад улаан эсвэл цагаан байх магадлал $\frac{1}{4}$, цагаан эсвэл ногоон байх магадлал $\frac{2}{3}$ байв.

а. P(ногоон байх)=

б. P(улаан байх)=

б. P(Улаан эсвэл ногоон байх)=

Дасгалын дугаар																			Нийт
Өөрийн үнэлгээ																			
Багшийн үнэлгээ																			

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

Сурагчийн овог нэр: _____ Эхэлсэн ... он ... сар ... өдөр ... цаг

СЭДЭВ: НИЙЦТЭЙ БА НИЙЦГҮЙ ҮЗЭГДЛҮҮД VIII-22.1-III

Үзэгдлийн магадлал нь тухайн үзэгдэлд харьяалагдах эгэл үзэгдлүүдийн магадлалын нийлбэртэй тэнцүү.

Үзэгдлүүд нийцтэй эсэхийг тогтоо.

1. Хоёр зоосыг зэрэг орхив.

Бүх боломжит үзэгдлийн олонлог =

а. A = “Эхний удаад нь сүлд буух”, B = “Эхний удаад нь тоо буух”

б. A = “Эхний удаад нь сүлд буух”, B = “Хоёрдахь удаад нь тоо буух”

Үзэгдлүүд нийцтэй эсэхийг тогтоогоод хэрэв нийцтэй бол огтлолцол олонлогийг бич.

2. 5 сурагч дугаарлан зогсов.

а. A = “Болд хамгийн ард зогссон байх”, B = “Бат хамгийн ард зогссон тоо байх”

$A \cap B = \{$_____$\}$

б. A = “Болд хамгийн ард зогссон байх”, B = “Бат хамгийн урд зогссон байх”

$A \cap B = \{$_____$\}$

3. 4 өөр өнгийн 4 бөмбөгтэй уутнаас нэг бөмбөг авч өнгийг тэмдэглээд буцааж хийгээд дахин нэг бөмбөг авчээ.

а. A = “Эхний бөмбөг улаан байх”, B = “Эхний бөмбөг ногоон байх”

$A \cup B = \{$_____$\}$

б. Хүснэгтийг нөхөж бичээд ашигла.

	Эхний бөмбөг улаан	Эхний бөмбөг улаан биш
Хоёрдахь бөмбөг ногоон байх	УН	ШН, ...
Хоёрдахь бөмбөг ногоон биш байх	УШ, ...	

A = “Эхний бөмбөг улаан байх”, C = “Хоёрдахь бөмбөг ногоон байх”

$A \cup C = \{$_____$\}$

A = “Эхний бөмбөг улаан байх”, D = “Хоёрдахь бөмбөг ногоон биш байх”

$A \cup D = \{$_____$\}$

4. Өмнөх бодлогын хүснэгт ашиглан өгсөн хоёр үзэгдлийн ядаж нэг нь илрэх үзэгдлийн магадлалыг ол.

$P(A \cup B) =$ $P(A \cup C) =$ $P(A \cup D) =$

5. Өгсөн үзэгдэлтэй нийцгүй болон нийцтэй үзэгдлийн жишээ бич.

Сурагч асуулт бүр нь 2 сонголттой 5 асуулттай тест бөглөжээ.

а. A = “Яг нэг асуултад зөв хариулсан байх”

б. B = “Ядаж 3 асуултад зөв хариулсан байх”

Дасгалын дугаар																			Нийт
Өөрийн үнэлгээ																			
Багшийн үнэлгээ																			

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

Сурагчийн овог нэр: _____ Эхэлсэн ... он ... сар ... өдөр ... цаг

СЭДЭВ: НИЙЦТЭЙ БА НИЙЦГҮЙ ҮЗЭГДЛҮҮД VIII-22.2-I

1. Сурагчдаас дуртай спортыг асууж, хүснэгтэд бүртгэжээ.

Дуртай спорт	Сурагчийн тоо
Сагсан бөмбөг	4
Усанд сэлэлт	1
Гар бөмбөг	1
Ширээний теннис	1
Хөл бөмбөг	3

Санамсаргүй нэг сурагч сонгов.

а. P(Сагсан бөмбөг сонирхдог байх)=

б. P(Гар бөмбөг сонирхдог байх)=

в. P(Гар бөмбөг эсвэл сагсан бөмбөг сонирхдог байх)=

г. P(Усанд сэлэлт эсвэл ширээний теннис сонирхдог байх)=

2. Хүүхдүүдээс ямар гадаад хэл судалдаг талаар нь судалгаа авч үр дүнг диаграммаар харуулав.
Эдгээр сурагчаас санамсаргүй 1 сурагч сонгожээ.



а. Туршилтад илрэх эгэл үзэгдлийн олонлогийн чадлыг ол.

б. P(зөвхөн нэг гадаад хэл судалдаг байх)=

в. P(Англи хэл судалдаг байх)=

3. М, А, Г, Д, Л, Р, Ш, Х гэсэн үсэгнүүдээс санамсаргүй 1 үсэг сонгов.

а. P(МАРГААН гэдэг үгэнд ордог үсэг байх)=

б. P(МАГАДЛАЛ эсвэл МАРГААШ гэсэн үгэнд ордог үсэг байх)=

4. 50 сурагчаас амьтан тэжээдэг эсэх талаар судалгаа авч үр дүнг хүснэгтэд харуулав.

	Нохой	Муур
Хөвгүүд	12	4
Охид	11	15

Санамсаргүй нэг сурагч сонгов.

P(хүү байх) = P(охин байх) =

P(нохой тэжээдэг байх) = P(муур тэжээдэг байх) =

P(Хүү байх эсвэл нохой тэжээдэг байх)= P(Нохой тэжээдэг хүү байх)=

5. Уутанд байгаа 30 бөмбөгний 10 нь улаан, 6 нь цэнхэр бөмбөг, үлдсэн нь ногоон болон шар бөмбөгнүүд бөгөөд санамсаргүй нэг бөмбөг авахад шар бөмбөг гарч ирэх магадлал $\frac{1}{6}$ байв. Уутнаас санамсаргүй 1 бөмбөг авав.

а. P(ногоон бөмбөг байх)= б. P(ногоон эсвэл шар бөмбөг байх)=

в. P(улаан эсвэл цэнхэр бөмбөг байх)= г. P(Улаан эсвэл цэнхэр эсвэл шар бөмбөг байх)=

Дасгалын дугаар																			Нийт
Өөрийн үнэлгээ																			
Багшийн үнэлгээ																			

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

Сурагчийн овог нэр: _____ Эхэлсэн ... он ... сар ... өдөр ... цаг

СЭДЭВ: НИЙЦТЭЙ БА НИЙЦГҮЙ ҮЗЭГДЛҮҮД VIII-22.2-II

1. 2 оронтой 1 тоо санамсаргүй сонгов.

P(3-т хуваагддаг тоо байх эсвэл 3-т хуваагддаггүй тоо байх)=

P(16-д хуваагддаг тоо байх эсвэл 7-д хуваагддаг тоо байх)=

2. Хэсэг сурагчийн насыг бүртгэв. Эдгээр сурагчаас санамсаргүй нэг сурагч сонгох болов.

Нас	Сурагчийн тоо
10	4
11	14
12	16
13	6

P(10 эсвэл 11 настай байх)=

P(11-ээс бага эсвэл 12-оос их настай байх)=

P(12-оос бага эсвэл 11-ээс их настай байх)=

3. 100-аас ихгүй хэдэн тоог нэг нэг цаасан дээр бичиж уутанд хийв. Санамсаргүй нэг тоо сонгоход 50-аас их тоо таарах магадлал 0.45, 90-ээс бага тоо таарах магадлал 0.9 байв.

P(50-аас ихгүй эсвэл 90-ээс багагүй тоо таарах)=

4. Зоосыг 4 удаа орхив.

P(Бүгд тоо буух)= *P*(Бүгд сүлд буух)=

P(бүгд тоо эсвэл бүгд сүлд буух)=

5. 3 цагаан, 6 улаан, 5 цэнхэр бөмбөгнөөс санамсаргүй 2 бөмбөг авчээ.

P(Хоёулаа цагаан байх)=

P(Хоёр өөр өнгөтэй байх)=

P(Хоёулаа цагаан эсвэл хоёр өөр өнгөтэй байх)=

6. 3 цагаан, 2 улаан, 3 цэнхэр бөмбөгнөөс санамсаргүй 3 бөмбөг авчээ. Бүгд ижил өнгөтэй эсвэл бүгд өөр өнгөтэй байх үзэгдлийн магадлалыг ол.

P(Бүгд ижил өнгөтэй байх)=

P(Бүгд өөр өнгөтэй байх)=

P(бүгд ижил эсвэл бүгд өөр өнгөтэй байх)=

Дасгалын дугаар																			Нийт
Өөрийн үнэлгээ																			
Багшийн үнэлгээ																			

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

Сурагчийн овог нэр: _____ Эхэлсэн ... он ... сар ... өдөр ... цаг

СЭДЭВ: НИЙЦТЭЙ БА НИЙЦГҮЙ ҮЗЭГДЛҮҮД VIII-22.2-III

1. Ангийн сурагчдын 50% нь аялалд явав. Дараа нь 60% нь тэмцээнд оролцжээ. Хүүхэд бүр ядаж нэг арга хэмжээнд оролцсон байв. Ангиас нэг сурагч санамсаргүй сонгов.

P(аялалд явсан байх) = P(тэмцээнд оролцсон байх) =

P(Хоёуланд нь оролцсон байх) = P(зөвхөн тэмцээнд оролцсон байх) =

P(зөвхөн аялалд явсан байх) = P(алинд ч оролцоогүй байх) =

2. Хоёр оронтой тоо сонгов.

а. P(5-аар төгссөн эсвэл цифрүүдийн нийлбэр 10 байх)=

б. P(5-аар төгссөн эсвэл 13-д хуваагддаг тоо байх)=

в. P(5-аар төгссөн эсвэл 17-д хуваагддаг тоо байх)=

г. P(5-аар төгссөн эсвэл 23-д хуваагддаг тоо байх)=

3. Хүрд эргүүлэх туршилт хийхэд дараах үр дүнгүүд гарчээ.

P(зүү нь тэгш тоог заах)=0.8, P(5-д хуваагддаг тоог заах)=0.5,
P(10-д хуваагддаг тоог заах)=0.4

P(Тэгш тоо заах эсвэл 5-д хуваагддаг тоог заах)=

4. 3 улаан, 2 шар, 3 цэнхэр бөмбөгтэй уутнаас нэг бөмбөг авч өнгийг тэмдэглээд буцааж хийгээд дахин нэг бөмбөг авчээ.

а. A= “Эхний бөмбөг улаан байх”, B= “Хоёрдахь бөмбөг шар байх” бол хүснэгтийг нөх.

	A	$\overline{A}$
B		
$\overline{B}$		

б. P(Эхний бөмбөг улаан эсвэл хоёрдахь бөмбөг шар байх)=$P(A \cup B)$=

5. 3 улаан, 2 шар, 2 цэнхэр бөмбөгтэй уутнаас нэг бөмбөг авч өнгийг тэмдэглээд буцааж хийхгүйгээр дахин нэг бөмбөг авчээ.

а. A= “Эхний бөмбөг улаан байх”, B= “Хоёрдахь бөмбөг шар байх” бол хүснэгтийг нөх.

	A	$\overline{A}$
B		
$\overline{B}$		

б. P(Эхний бөмбөг улаан эсвэл хоёрдахь бөмбөг шар байх)=$P(A \cup B)$=

Дасгалын дугаар																			Нийт
Өөрийн үнэлгээ																			
Багшийн үнэлгээ																			

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

Сурагчийн овог нэр: _____ Эхэлсэн ... он ... сар ... өдөр ... цаг

СЭДЭВ: ХАРЬЦАНГУЙ ДАВТАМЖ БА МАГАДЛАЛ VIII-22.3-II

1. Уутнаас 1 бөмбөг авах туршилт хийхэд зориулан уутанд улаан, шар, ягаан өнгийн 1260 бөмбөг хийх болов. Улаан байх магадлал нь $\frac{1}{4}$, шар байх магадлал нь $\frac{1}{4}$, ягаан байх магадлал нь $\frac{1}{2}$ байхын тулд өнгө бүрээс хэдэн бөмбөг хийх вэ?

2. Өгүүлэл дэх үг бүр хэдэн үсэгнээс тогтож байгааг бүртгэж диаграммаар харуулжээ. Санамсаргүй 1 үг сонгов.

Хэдэн үсэгнээс бүтсэн үг таарах харьцангуй давтамж хамгийн их вэ? Энэ нь өгөгдлийн ямар дунджийг илэрхийлэх вэ?

Хэдээс цөөнгүй үсэгтэй үг таарах харьцангуй давтамж 0.5 байна вэ? Энэ нь ямар дунджийг илэрхийлэх вэ?

Нийт үгийн тоо:

Х.Д (6-аас олон) =

Х.Д (4-өөс олон цөөн) =

Х.Д (4-өөс цөөнгүй, 6-аас олонгүй) =

3.



Өрхийн зардлыг диаграммаар харуулжээ.

Х.Д (Хувцас) =

Х.Д (Эрчим хүч) =

Х.Д (Эрчим хүч, унаа) =

4. Бат зурагт өгсөн хүрдийг 70 удаа эргүүлжээ. Хүрдний зүү



а. цэнхэр өнгөн дээр хэдэн удаа туссан байх боломжтой вэ?

б. улаан эсвэл шар өнгө дээр нийт хэдэн удаа туссан байх боломжтой вэ?

в. тусах магадлал нь 0.6 байх үзэгдэл бич.

5. 25 сурагчийн нэрийг малгайнд хийгээд санамсаргүй 5 нэр авахад 3 эрэгтэй, 2 эмэгтэй хүүхдийн нэр гарч ирэв.

Эрэгтэй хүүхдийн тоо ойролцоогоор

Эмэгтэй хүүхдийн тоо ойролцоогоор

Дасгалын дугаар																			Нийт
Өөрийн үнэлгээ																			
Багшийн үнэлгээ																			

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

Сурагчийн овог нэр: _____ Эхэлсэн ... он ... сар ... өдөр ... цаг

СЭДЭВ: ХАРЬЦАНГУЙ ДАВТАМЖ БА МАГАДЛАЛ VIII-22.3-III

1. Уутнаас нэг бөмбөг гаргах туршилт хийхийн тулд цэнхэр, улаан, ногоон, шар, ягаан, бор өнгийн нийт 400 бөмбөг уутанд хийх болов.

Хамгийн олондоо хоёр өнгийн хувьд гарч ирэх боломж нь тэнцүү байхаар тохируул.

P(Цэнхэр)_____, цэнхэр бөмбөгний тоо _____

P(Улаан)_____, улаан бөмбөгний тоо _____

P(Ногоон)_____, ногоон бөмбөгний тоо _____

P(Шар)_____, шар бөмбөгний тоо _____

P(Ягаан)_____, ягаан бөмбөгний тоо _____

P(Бор)_____, бор бөмбөгний тоо _____

2. Сурагчдын дуртай спортын төрлүүдийг диаграммаар харуулав. Санамсаргүй 1 сурагч сонгов.



Нийт сурагчийн тоо _____

P(хөлбөмбөг сонирхдог байх) =

P(хөлбөмбөг сонирхдог хүү байх)=

P(хүү эсвэл хөлбөмбөг сонирхдог байх) =

P(охин эсвэл талбайн теннис сонирхдог байх) =

3. 6, 7, 8, 9, 10 настай нийт 12 хүүхэд байв. Санамсаргүй нэг сурагч сонгоход
8 настай сурагч сонгогдох магадлал хамгийн их,
нас нь 7-оос их байх магадлал 0.5, 6 настай сурагч сонгогдох магадлал 0.25 байв.

Сурагчдын насыг бүртгэвэл өгөгдлийн моод нь хэд байх вэ?

Өгөгдлийн медиан хэд байх вэ?

7 настай хэдэн сурагч байна вэ?

9 настай сурагч хэд байх вэ?

4. 4 хэсэгт хуваах, 1, 2, 3, 4 гэсэн тоо бичсэн хүрдийг эргүүлэх туршилт хийжээ. Зүү нь “3” тоон дээр зогсох харьцангуй давтамж $\frac{1}{6}$, “3 эсвэл 4” тоон дээр зогсох харьцангуй давтамж $\frac{1}{3}$, анхны тоон дээр эсвэл тэгш тоон дээр зогсох харьцангуй давтамж $\frac{2}{3}$ байв.

Тоо бүр дээр зогсох үзэгдлийн харьцангуй давтамжийг ол. Ойролцоогоор зур.

Х.Д(4 тоон дээр зогсох) =

Х.Д(1 тоон дээр зогсох) =

Х.Д(2 тоон дээр зогсох) =

Дасгалын дугаар																			Нийт
Өөрийн үнэлгээ																			
Багшийн үнэлгээ																			

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

Сурагчийн овог нэр: _____ Эхэлсэн ... он ... сар ... өдөр ... цаг

ТЕСТ 22. ҮЗЭГДЛИЙН МАГАДЛАЛ VIII-22

1. Туршилтад илрэх A ба B үзэгдлүүдийн хувьд $P(A)=P(B)=\frac{2}{3}$ бол A ба B үзэгдлүүд нийцтэй эсэхийг тогтоо. Дэлгэрэнгүй бодолт хийнэ үү.

2. Нийцгүй A ба B үзэгдлүүдийн магадлал харгалзан 0.5, 0.3 бол ядаж нэг нь илрэх үзэгдлийн магадлал аль вэ?

А. 0.15 Б. 0.8 В. 0.2 Г. 0.6

3. 52 модтой хөзрөөс санамсаргүй 1 хөзөр сугалахад “Тамга эсвэл улаан өнгийн 10 байх” үзэгдлийн магадлал аль вэ?

А. $\frac{3}{26}$ Б. $\frac{3}{52}$ В. $\frac{1}{26}$ Г. $\frac{1}{52}$

4. 19-өөс бага натурал тоонуудын олонлогоос санамсаргүй нэг тоо сонгов.
A = “18-ын хуваагчид”, $B = \{2n \mid n<10\}$ бол $P(A\cup B)$-г ол.

А. $\frac{2}{15}$ Б. $\frac{1}{6}$ В. $\frac{1}{5}$ Г. $\frac{1}{10}$

5. 3 оронтой тоо сонгов. Бүх цифр ижил эсвэл бүх цифр нь өөр байх үзэгдлийн магадлал аль вэ?

А. $\frac{7}{9}$ Б. 0.5 В. 0.57 Г. 0.73

6. 6 охин, 5 хүүгээс хоёр хүүхэд сонгов. A = ”хоёул охин байх”, B = ”хоёул хүү байх” бол $P(A\cup B)$-г ол.

А. $\frac{1}{30}$ Б. $\frac{4}{11}$ В. $\frac{5}{11}$ Г. $\frac{2}{15}$

7. 3 цагаан, 6 улаан, 5 цэнхэр бөмбөгнөөс санамсаргүй 3 бөмбөг авчээ. Нэг нь цагаан эсвэл 2 нь цэнхэр байх магадлалыг ол. Дэлгэрэнгүй бодолт хийнэ үү.

Дасгалын дугаар																				Нийт
Өөрийн үнэлгээ																				
Багшийн үнэлгээ																				

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг